



**“КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН
КОДЕКС”-ИЙ ХЭРЭГЖИЛТИЙН
ТАЙЛАН**

“БЛЮСКАЙ СЕКЬЮРИТИЗ ҮЦК” ХК

/BSKY/

УЛААНБААТАР ХОТ
2022 ОНЫ 11 САР

Үнэлгээний нэгдсэн дүн

№	Гарчиг	Авбал зохих нийт оноо	Үнэлсэн оноо	Хяналтын оноо	Үнэлгээний хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	10		83.3%
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	10		100%
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	4		66.6%
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	6		100%
5	Эрсдэлийн удирдлага	8	6		75%
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	5		83.3%
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	8		100%
8	Компанийн соёл	6	6		100%
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	8		80%
	Нэгдсэн дүн	72	63		87.5%



ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

Энэхүү үнэлгээний аргачлалын дагуу “Блюескай Секьюритиз ҮЦК” ХК (цаашид компани гэх)-ийн “Компанийн засаглалын кодексе”-ийн хэрэгжилтийн үнэлгээг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга хийж гүйцэтгэсэн бөгөөд үр дүнг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга хянаж баталсан болно.

Үнэлгээний бүтэц

“Компанийн засаглалын кодексе”-ийн үнэлгээний загвар нь нийт 36 асуулга бүхий дараах бүтэцтэй тайлан байна. Үүнд:

1. ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт
2. ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг
3. Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал
4. Аудит, хяналтын тогтолцоо
5. Эрдэлийн удирдлага
6. Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал
7. Оролцогч талуудын эрх ашнг
8. Компанийн соёл
9. Хувьцаа эзэмшигчдийн эрх

Үнэлгээний аргачлал

Асуулга тус бүрийн хувьд бүрэн хэрэгжүүлсэн, эсхүл үндэслэл бүхий тайлбар гаргасан бол 2, хэсэгчлэн хэрэгжүүлсэн, эсхүл хугацаа бүхий хэрэгжүүлэх арга хэмжээ, зорилтоо тайлбарласан бол 1, үнэлгээ ирүүлээгүй бол 0 гэсэн оноогоор тус тус үнэлэх ба хэрэгжилт болон тайлбарыг тус бүрээр нь оруулав.

Үнэлгээний нэгдсэн дүнд үндэслэн “Компанийн засаглалын кодексе”-ийн хэрэгжилтийг дараах байдлаар үнэлнэ:

- авбал зохих нийт онооны 90 хувь болон түүнээс дээш байвал засаглал хэвийн буюу эрдэлгүй;
- 70-89 хувь байвал дунд засаглалтай буюу цаашид эрдэл үүсч болзошигүй тул зөвлөмж хүргүүлэх;
- 50-69 хувь байвал хангалтгүй засаглалтай буюу эрдэлтэй тул зайны болон газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн;
- 49 болон түүнээс доош хувьтай бол муу засаглалтай буюу үйл ажиллагаа нь өндөр эрдэлтэй тул зохицуулалтын арга хэмжээ авах шаардлагатай.



Компанийн засаглалын үндэглэний асуулга					
<p>Кодексийн хэрэгжилтийг “Хэрэгжүүл, эсвэл тайлбарла” гэсэн зарчмын дагуу тайлагнах зүйл тус бүрээр биелүүлсэн эсэх, биелүүлээгүй бол яагаад биелүүлээгүй, түүнийг орлох бүтэц, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, эсхүл авч байгаа, хэрэв төлөвлөж буй бол хугацаатайгаар нь тайлбар хэсэгт тусгана.</p>					
НЭГ, ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ					
<p>ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал тэргийн зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна</p>					
№	Зүйл	Хэрэгжилт	Тайлбар	Оноо	Хувь
1	1.1. Компани нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.	Бүрэн хэрэгжүүлсэн	“Блюескай Секьюритиз ҮЦК” ХК-ийн ТУЗ-ийн 2022 оны 11 сарын 11-ний өдрийн тогтоолоор “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг шинэчлэн баталж ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, хороодын чиг үүрэг хариуцлагыг нарийвчлан тусгасан. /Журмыг хавсаргав/	2	100
2	1.2. Компани нь ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, төмилөх асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримттай байна.	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд тусгасан. Компани залгамж халааны бодлогын баримт бичгийг “Блюескай Секьюритиз ҮЦК” ХК-ийн ТУЗ-ийн 2022 оны 11 сарын 11 өдрийн ТУЗ-ийн хурлын тогтоолын хавсралтаар баталсан. /хавсаргав/	2	100
3	1.3. ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, цахим хуудсандаа байршуулна.	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн	Компанийн жилийн эцсийн үйл ажиллагааны тайланд холбогдох мэдээлэл оруулан тайлагнадаг. Хөрөнгийн биржийн цахим хуудас болон өөрийн компанийн цахим хуудсанд мэдээлэл байршуулна.	1	50
4	1.4. Компани нь ТУЗ болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримттай байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэрт байдал зэргийг тусгана.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн дүрэм болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд ТУЗ болон хороодын бүтэц, бүрэлдэхүүн түүний гишүүдэд тавигдах шаардлага зэргийг тусган ТУЗ-ийн 2022 оны 11 сарын 11-ний өдөр “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг шинэчлэн баталсан. Хавсаргав.	2	100

5	1.5. ТУЗ-ийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, тэдгээрийг шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн	Шинээр томилогдсон гишүүдийг компанийн засаглалын сургалтад хамруулдаг боловч сүүлд томилогдсон гишүүдээ цөөн тооны гишүүн хамрагдаагүй байна.	1	50
6	1.6. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар ТУЗ-ийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд тусган ажилладаг ба ТУЗ-ийн даргын чиг үүргийн дор ажлын албаны үүргийг хариуцдаг.	2	100
ДҮН				10	83.3
ХОЁР. ТУЗ-НИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ					
ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эрсийн хариуцлагыг хүлээнэ					
7	2.1. ТУЗ-ийн дарга болоод ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүнбайхыг зорино.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн дүрэмд заасны дагуу ТУЗ-ийн 1/3 нь хараат бус гишүүн байхаар заасан боловч журамдаа ТУЗ-ийн гишүүдийн олонхийг хараат бус гишүүн байхыг зорьж ажиллах талаар заалт оруулсан. ТУЗ-ийн даргаар хараат бус гишүүний шинж чанар хангасан хүнийг сонгосон.	2	100
8	2.2. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд зааснаар ТУЗ-ийн Аудитын хороон даргаар Хараат бус гишүүн ажиллаж байгаа бөгөөд ТУЗ-н дарга бус хүн томилогдсон. Хуралд оролцох тохиолдолд тус хорооны хүсэлтээр оролцдог.	2	100

9	<p>2.3. ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлагыг сахихуу хорооны хүсэлтээр оролцоно.</p>	<p>Бүрэн хэрэгжүүлсэн</p>	<p>Компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд зааснаар ТУЗ-ийн Цалин урамшуулалын хорооны даргаар Хараат бус гишүүн ажиллаж байгаа бөгөөд ТУЗ-дарга бус байдаг. Хуралд оролцох тохиолдолд тус хороон хүсэлтээр оролцдог.</p>	2	100
10	<p>2.4. ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.</p>	<p>Хэсэгчлэн хэрэгжүүлсэн</p>	<p>Компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд зааснаар ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хорооны даргаар Хараат бус гишүүн ажиллаж байгаа бөгөөд ТУЗ-дарга бус байдаг. Хүний нооцийн бодлого дотроо залгамж халааны бодлогын заалтуудыг тусгасан.</p>	2	100
11	<p>2.5. ТУЗ нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. ТУЗ-ийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүрэг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын турилгай бүхий бүрэлдэхүүнтэй байна.</p>	<p>Бүрэн хэрэгжүүлсэн</p>	<p>Компанийн дүрмэнд шаардлагатай үед түр хороо байгуулж болно гэж тусгасан байдаг. Аудит, цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хороодууд өөрийн тусгайлан журам заавартай.</p>	2	100

ДҮН			10	100	
ГУРАВ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ					
ТУЗ нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үгэл, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана					
12	3.1. ТУЗ нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн албан ёсны цахим хуудас www.bsky.mn Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас www.msc.mn хаягаар хувьцаа эзэмшигч болон хөрөнгө оруулагч, олон нийтэд санхүүгийн тайлан болон хурлын мэдээлэлээ нээлттэй тайлагнадаг.	2	100
13	3.2. ТУЗ нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн	Компанийн албан ёсны цахим хуудас www.bsky.mn хаягаар хувьцаа эзэмшигч болон хөрөнгө оруулагч, олон нийтэд хүргэнэ	1	50
14	3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн төгтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсхийг үнэлсэн мэдээлэл байна.	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн	Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг олон нийтэд нээлттэй байршуулдаг. Цаашид тайланд хөндлөнгийн аудитын дүгнэлт, аюулгүй байдал, байгаль орчин, нийгмийн харьцуулалт, цаашид зорилт, тогтвортой хөгжлийн талаар мэдээллүүдийг бэлтгэн оруулах болно.	1	50
ДҮН			4	66.6	
ДӨРӨВ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТГОЛЦОО					
ТУЗ нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана					
15	4.1. ТУЗ нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, түүнийг хуульд заасан чиг үүрэгт саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд зааснаар ТУЗ-ийн Аудитын хороо хөндлөнгийн аудитыг сонгох боломж нээлттэй бус зохицуулагдсан. Дүгнэлтийг гүйцэтгэх удирдлага ТУЗ-д танилцуулдаг.	2	100

16	4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн элэгсэт хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.	Бүрэн хэрэгжүүлсэн	Хөндлөнгийн аудитын гаргасан дүгнэлтийг хувьцаа эзэмшигчийн элэгсэт хуралд компанийн удирдлагууд танилцуулдаг. МХБиржийн цахим хуудсанд дүгнэлтийг байршуулан ажилладаг.	2	100
17	4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, тэдгээрт өрсөн оорчлолтийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар олон нийтэд тухай бүр мэдээлнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн дүрэм, дотоод журам, бүтэц бүрэлдэхүүнд тусгасны дагуу дотоод хяналтыг ажиллуулдаг бөгөөд цаашид олон нийтэд мэдээллэж ажиллана.	2	100
ДҮН				6	100
ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА					
ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон компайнсын хяналтыг зохиотой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, гэдгээрийн үр дүнгтэй байдалд тогтмол хяналт тавина					
18	5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.	Бүрэн хэрэгжүүлсэн	Эрсдэлийн удирдлагын бодлоготой ба ТУЗ хяналтавыж, зөвлөгөө өгч ажилладаг.	2	100
19	5.2. ТУЗ нь дэргэд эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана.	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн	Компанийн дүрэмд Дэд хороо байгуулж болох талаар тусгагдсан ба хорооны бүтцийн хувьд 2/3 нь хараат бус гишүүн байхаар зохицуулагдсан. Тиймээс цаашид ТУЗ-ийн дэргэд эрсдэлийн удирдлагын хороотой байхыг зорино.	1	50
20	5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн харьцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн	Эрсдэлийн удирдлагын бодлогод холбогдох заалтыг тусгайсан байгаа боловч цаашид үнэлэн нийтэд мэдээлж ажиллана.	1	50

21	5.4. Компани нь компанийсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба компанийсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.	Бүрэн хэрэгжүүлсэн	Тусгайлсан өөрийн журамтай. Холбогдох тйалан мэдээг гаргаж, Санхүүгийн мэдээлэлийн албанд холбогдох мэдээлэлийг явуулж ажилладаг. Гүйцэтгэх удирдлага болон дотоод хяналтын ажилтан хяналттавьж ажилладаг.	2	100
ДҮН				6	75
ЗУРГАА. ЭРХ БҮХНИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын харна, онцлогт тохирсон, шуларга, ил тод байна					
22	6.1. ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэллцэж батална.	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн гишүүдэд одоогоор ямар нэгэн цалин шагнал урамшуулал огдоггүй тул хэлцэхгүй байгаа. Цаашид цалин, урамшуулал өгөх нохцол бүрдсэн үед хэллцэж батална.	1	50
23	6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримтад тусгана.	Бүрэн хэрэгжүүлсэн	Ходолмөрийн дотоод журам, цалин, урамшуулалын журам, ажил үүргийн бүрдэл хэсэг зэргийг тусгаасан байдаг. Хавералтаар хүргүүлэв.	2	100
24	6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын хооронд байгуулсан гэрээнд цалин, урамшуулалын хэмжээг тусгайлан заасан байдаг.	2	100
ДҮН				5	83.3
ДОЛОО. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ					
25	7.1. Компани нь ТУЗ-оос баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн дүрэм болон Гүйцэтгэх удирдлагатай байгуулсан гэрээнд тусгайлан заасан байдаг. Цаашид илүү анхаарч ажиллана.	2	100

26	7.2. Компанийн эсгийг үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн үйл ажиллагааны тайланд ач холбогдол бүхий талууд, хөрөнгө оруулагч нартай хамтран ажилласан талаар мэдээлэл танилцуулдаг.	2	100
27	7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн цахим хуудсыг үйл ажиллагаандаа ашиглаж байна. мэдээллийг нээлттэй байрлуулж ажиллах тал дээр анхаарна.	2	100
28	7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журамыг баталсан. Хавсаргав	2	100
ДҮН				8	100
НАЙМ. КОМПАНИЙН СОЁЛ					
ТУЗ-ийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн ондөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно					
29	8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор ТУЗ нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Бүрэн хэрэгжүүлсэн	“Ёс зүйн дүрэм” баталсан ба үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Хавсаргав	2	100
30	8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зорчлийг ТУЗ, эсвэл түүний дэргэдэх холбогдох хөрөөнд мэдээлэх “шүгэл үлээгчийн” тогтолцоотой байна.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн үйл ажиллагааны журамд тодорхой хэлбэрээр буюу “Ёс зүйн дүрэм”-д заасан.	2	100
31	8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.	Бүрэн хэрэгжүүлсэн	“Ёс зүйн дүрэм”-д тодорхой заасан ба хэрэгжүүлэн ажиллаж байна.	2	100
ДҮН				6	100
ЕС. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ					
Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана					

32	9.1. Компани оролцогч талуудад өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын бүтэц, зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа тухай бүр хүргэнэ.	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн	Компаги хагас, бүтэн жилээр үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан гаргаж хоронгийн биржийн цахим хуудсаар дамжуулан олон нийт, хоронгө оруулагч нарт мэдээллэж байгаа. Цаашид өөрийн цахим хуудсаар мэдээлэл оруулж ажиллана. 2023 онд	1	50
33	9.2. Компани хоронгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба тэдлнтэй харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн	Компанийн үйл ажиллагааны тайланд тусган мэдээлэл хүргүүлэн ажилладаг. Цаашид хөтөлбөрийг бэлтгэн ажиллахыг зорино.	1	50
34	9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, ноцлолийг бүрдүүлнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн	хувьцаа эзэмшигчид хуралд оролцох, санал гаргах, мэдээлэл авах бүрэн боломжтой байдаг бөгөөд жил бүр үйл ажиллагааны тайлан мэдээллийг олон нийтэд нээлттэй мэдээллэдэг.	2	100
35	9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтцийн асуудлаар хувьцаа эзэмшигчдээс санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.	Бүрэн хэрэгжүүлсэн	Нээлттэй хувьцаат компани учир энэ асуудлаар хувьцаа эзэмшигч эрхээ хэрэгжүүлэхэд ямар нэг асуудал гардаггүй	2	100
36	9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхол зорчигдохоос сэргийлэх зорилгоор сонирхлын зорчилтэй хэлцэл хийх журамтай байх ба хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн дүрэмд зааснаар ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавьж дүгнэлт гаргах ба Хувьцаа эзэмшигчдийн хурал уг хэлцлийг баталдаг.	2	100
ДҮН				8	80
НЭГДСЭН ДҮН					87.5

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга  Ариун-Эрдэнэ

ТАЙЛАНГ ХЯНАЖ БАТАЛСАН:

ТУЗ-ийн дарга  Г.Оюунболд

2022.11.14